



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

┌ Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх ┐
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 39 дүгээр зүйлийн 39.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Практикал даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгч Шижирбаатарын Цэндболдын даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тогтоол батлагдсантай холбогдуулан даатгалын гэрээ, баталгааны үлдэгдлийн тооцоог хийж, ажлын 10 хоногийн дотор Хороонд мэдэгдэхийг “Практикал даатгал” ХХК /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн
157 дугаар тогтоолын хавсралт



Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох иргэний мэдээлэл

№	Овог	Нэр	Регистр	Тусгай зөвшөөрөл авсан огноо	Шийдвэрийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	Шижирбаатар	Цэндболд	ЕЛ88120711	2011.11.01	173 дугаар тушаал	2/06/231/394